



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/16д.

Бат-Өлзий сум

Архи, согтууруулах ундаа худалдах,  
түүгээр үйлчлэхийг түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын “Ээлжит цэрэг татлага явуулах тухай” 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/427 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Цэргийн штабын 2022 оны Б/92 дугаар албан бичгээр өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, сумын 2022 оны ээлжит цэрэг татлага зохион байгуулахтай холбогдуулан нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 07, 08, 09-ны өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг түр хугацаагаар хориглосугай.

2. 2022 оны ээлжит цэрэг татлагыг үеэр архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдийг тухай өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдаалахгүй, түүгээр үйлчлэхгүй байхад хяналт тавьж ажиллахыг Д.Энх-Амгалан (Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад), багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэхүү шийдвэрийг архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүр, үйлчилгээний газруудад мэдэгдэхийг Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (М.Мягмаржав)-д даалгасугай.

ОРЛОГЧ  Н.ОРХОНТУУЛ

